

3.3. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ

2024.12.13

Шийд- вэрийн Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Биелэлт гаргах нэгж	Хувь
Засгийн газрын тогтоол						
1.	1	2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарлах тухай 2023-12-27 Дугаар 2023_481	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг боловсруулах, холбогдох тооцоо, судалгаа хийх, санал өгөх чиглэлээр хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагад даалгаж, нутгийн өөрөө удирдах байгууллага, улс төрийн нам, эвсэл, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад уриалсугай.	Засгийн газраас 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан “Тавантолгой төмөр зам” ХХК нь 5 чиглэл, 18 ажил, арга хэмжээтэй төлөвлөгөөг боловсруулан Гүйцэтгэх захирлаар батлуулсан. Төлөвлөгөөнд тусгагдсан 18 арга хэмжээний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар 100%-6, 90%-6, 70%-6, Хугацаа болоогүй-1 нийт хэрэгжилт 90% хувьтай үнэлэгдэж, 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 4/1035 тоот албан бичгээр хүргүүлсэн.	ТТЗ ХХК	90%
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл						
2	1	2023 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 28 дугаар тэмдэглэл	1.8. Бодь интернэйшнл компани төмөр замын зүтгүүр оруулж ирэх хуваарийг нарийн гаргаж	Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын төсөл 98.7 хувийн гүйцэтгэлтэй байна. АНУ-аас ирэх SD70ACE/LW серийн зүтгүүрүүд 2024 оны 01 дүгээр сараас 2024 оны 08 дугаар сар хүртэл нийт 4 үе шаттайгаар Монгол улсад нийлүүлэгдэхээр	ТТЗ ХХК	100%

		2023-07-05 Дугаар 2023_28	өгөх, хуваарийн дагуу “Монголын төмөр зам” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай ажлаа уялдуулах	төлөвлөгдсөн ба I ээлжийн 2 ширхэг зүтгүүр 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр, II ээлжийн 4 ширхэг зүтгүүр 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр, III- ээлжийн 4 ширхэг зүтгүүр 2024.07.02-ны өдөр, IV- ээлжийн 6 ширхэг зүтгүүр 2024.09.24-ний өдөр Монгол Улсад тус тус хүлээн авч тээврийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Тээврийн төлөвлөгөөтэй уялдуулан Төмөр замын салбарт ижил үйл ажиллагаа эрхэлж буй бусад компаниудад өөрийн эзэмшлийн хөдлөх бүрэлдэхүүний дэмжлэг үзүүлэх зорилгоор ашиглалтад бэлэн болсон зүтгүүрээс 2 зүтгүүрийг УБТЗ ХНН-т 2024 оны 07 дугаар сарын 16-ний өдрийн ТҮГ-2024/16 тоот "Зүтгүүр түрээсийн гэрээ"-ээр, мөн 2 зүтгүүрийг МТЗ ТӨХК-д 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн ТҮГ-2024/18 тоот "Зүтгүүр түрээсийн гэрээ"-ээр тус тус ашиглуулж байна.		
3	2	2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 45 дугаар тэмдэглэл 2023-11-08 Дугаар 2023_45	XI.1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг судалж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцож, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав;	Unelgee.gov.mn сайтад “Тавантолгой төмөр зам” ХХК-д хамаарах Засгийн газрын тогтоол- Дугаар 2023_481, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-2023 оны 6, 28, 45, дугаар тэмдэглэлүүд, 2024 оны 10 дугаар тэмдэглэлийн хэрэгжилт 90-100%- тай хэрэгжиж байна.	ТТЗ ХХК	100%
4	3	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын	13.6.2. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын	“Чайна Энержи Ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт” хязгаарлагдмал компаниас 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр	ТТЗ ХХК	90%

		13-ны өдрийн хуралдааны 10 дугаар тэмдэглэл 2024-03-13 Дугаар 2024_10	барилга угсралтын ажлын гэрээг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан зохих журмын дагуу байгуулах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, “Эрдэнэс Тавантолгой” ХК дахь Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Будбаяр нарт, төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг мөн оны 2 дугаар улиралд багтаан эхлүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Будбаяр нарт тус тус даалгав;	замын бүтээн байгуулалтыг хамтран барих тухай хэлэлцээрийн төсөл”-ийн 1.4-т “Монголын талын хил дамнасан төмөр замын барилгын ажлын гүйцэтгэгчээр Хятадын хил доторх Хятадын талын тодорхойлсон Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгож болох бөгөөд Монголын талын барилгын ажил гүйцэтгэх гэрээг “Тавантолгой төмөр зам” ХХК болон гүйцэтгэгч нар харилцан тохиролцож гарын үсэг зурна” хэмээн өөрчлөлт оруулан, 4.9-д “Хилийн хамгаалалтын бүсийн хашаан доторх барилгын ажлын цар хүрээг төмөр замын шугамыг төв болгож, баруун, зүүн тийш 50 метрийн зайд тус тус тогтоох бөгөөд хоёр талын компани нь өөр өөрийн хилийн хамгаалалт, хилийн шалган нэвтрүүлэх, гааль зэрэг байгууллагуудыг хариуцаж барилга угсралтын ажилд үйлчилгээ үзүүлнэ” нэмэлтээр тус тус ирүүлсэн байна. Тус 4.9 дэх заалтын хүрээнд хэлэлцээрийн төсөлд санал авахаар 6/2497, 6/2498 дугаартай албан бичгээр Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн. БНХАУ-ын “Чайна Энержи Ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт” ХК-ийн зүгээс 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хамтран барих тухай хэлэлцээрийн төсөл”-ийн 1.4 болон 4.9 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг ирүүлсэн бөгөөд уг асуудлын хүрээнд холбогдох эрх бүхий байгууллага буюу Гаалийн ерөнхий газар болон Хил хамгаалах ерөнхий газраас тус тус санал авч, хэлэлцээрийн төсөлд оруулах Монголын талын саналыг боловсруулсан. Иймд боловсруулсан хэлэлцээрийн төсөл, түүнд оруулах санал, танилцуулга болон холбогдох албан бичгийг 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 1/2655 дугаар албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. “Чайна Энержи Ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт” хязгаарлагдмал компаниас “Гашуунсухайт-Ганцмод боомтын		
--	--	--	---	---	--	--

				хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хамтран барих тухай хэлэлцээрийн төсөл"-ийг 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр нэмэлтээр санал гаргасан ба тус саналтай холбоотойгоор цахим уулзалт хийхээр төлөвлөж байна.		
5	4	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл 2024-06-06 Дугаар 2024_22	37.1.1. “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий багийг орон нутагт үргэлжлүүлэн ажиллуулж, холбогдох албан хаагчдын албан томилолтын болон замын зардал, тээврийн хэрэгслийг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн дарга, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга (захирал) нарт	Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолоор баталсан Шинэ хоршоо хөдөлгөөнийг өрнүүлэх тухай тогтоолын хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн чиглэлийн дагуу нэр бүхий 10 ажилтныг 2024 оны 05 сарын 01-ний өдрөөс 06 сарын 27-ны өдрийг дуустал хугацаанд албан томилолтоор ажиллуулах Гүйцэтгэх захирлын А/80 дугаар тушаал баталж, 10 ажилтныг томилолтоор ажиллуулсан. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А-1/834 дугаартай “Мэдэгдэл хүргүүлэх тухай” албан бичигт дурдсан хөдөө ажлын суудлын 2 автомашиныг “Засгийн газрын автобааз” ТӨААТҮГ-т 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр актаар хүлээлгэн өгсөн. Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 01/403 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд “Засгийн газрын Авто бааз” ТӨААТҮГ-ын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 01/132 дугаар албан бичгийн хэрэгжилтийг хангаж, Гүйцэтгэх захирлын 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/79 дүгээр тушаалаар 5 тээврийн хэрэгслийн үйлчилгээний зардлыг зохих журмын дагуу холбогдох зардлаас шийдвэрлэсэн.	100%	
Дүгнэлт: 100%-3, 90%-2 = 96%						

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК